

ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛЬД МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь ҮБХИС-ийн Цэргийн хөгжмийн коллеж, Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд мэргэжлийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа, удирдлага зохион байгуулалт, сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, баталгаажуулах болон сурах, сургах харилцааг зохицуулахад оршино.

ҮБХИС-ийн захирлын 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/133 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон/

1.2 Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс, Монгол Улсын төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, Боловсролын болон Батлан хамгаалахын багц хуулиуд, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан Боловсролын болон Батлан хамгаалахын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудаас баталсан дүрэм, журмууд, Батлан хамгаалахын сайдын 2017 оны А/178 дугаар тушаалаар батлагдсан “ҮБХИС-ийн дүрэм” нь уг журмын эрх зүйн үндэс болно.

1.3 Үндэсний батлан хамгаалахын их сургуульд мэргэжлийн боловсрол олгох сургалтын журам, (цаашид “журам” гэнэ) түүнд нэмэлт оруулах, тодотгол хийх асуудлыг ҮБХИС-ийн захиргааны зөвлөлөөр хэлэлцэж, захирлын тушаалаар баталгаажуулж мөрдөнө.

1.4 **Мэргэжлийн боловсролын зорилго** нь суурь, бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой иргэнд батлан хамгаалах салбар, зэвсэгт хүчин болон төр, бизнес, олон нийтийн байгууллагад мэргэжлийн мэдлэг, ур чадвараа ашиглан ажил, үүргийг бүтээлчээр гүйцэтгэхэд шаардагдах цэргийн мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх болон мэргэшүүлэх чадамж эзэмшүүлнэ.

1.4.1. **Мэргэжил олгох сургалтын зорилго** нь захиалагч болон ажил олгогч байгууллагын эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцсэн гүйцэтгэх албан тушаалын цэргийн мэргэжлийн боловсролын зэрэгтэй цэргийн алба хаагчийг чанартай бэлтгэхэд чиглэгдэнэ.

1.4.2. **Мэргэшүүлэх сургалтын зорилго** /төгсөлтийн дараах сургалт/ нь цэргийн мэргэжил эзэмшсэн ахлагч нарт өмнө эзэмшсэн мэргэшлийн түвшинг ахиулах, харилцааны болон удирдах арга зүй эзэмшүүлэх, шинжлэх ухааны үндэслэлтэй шийдлийн хувилбар боловсруулж, оновчтой сонголт хийхэд шаардагдах мэдлэг, ур чадвар, чадамж бүхий мэргэшсэн даргалах албан тушаалын ахлагч бэлтгэнэ.

Хоёр. Сургалтын удирдлага, зохион байгуулалт

2.1. Мэргэжлийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагааг Сургалт, цэргийн алба хариуцсан тэргүүн дэд захирал, Сургалтын хэлтэс харьяаллын сургуулиудын захирал, Сургалт, эрдэм шинжилгээний албаны дарга удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана.

2.2. Сургалтын хэлтсийн чиг үүрэг:

2.2.1. Боловсролын тухай багц хуулиуд, холбогдох бусад дүрэм, журмуудыг баримтлан сургалтын бодлогыг тодорхойлж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

2.2.2. Боловсрол олгох сургалтын бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг ҮБХИС-ийн дүрэмд заасан эрх, үүргийн хэмжээнд удирдлагаар ханган зохион байгуулах;

2.2.3. Сургалтын бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийн гүйцэтгэл, үр дүн, чанарын баталгаажуулалтад тогтмол хяналт, дүн шинжилгээ хийх;

2.2.4. Мэргэжлийн боловсрол сургалтын бодлого төлөвлөлтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, сургалтын нэгдсэн бүртгэл, мэдээллийн сан бүрдүүлж, тайлан, мэдээлэл гаргах;

- 2.2.5. Багшийн орон тоо, бүртгэл мэдээлэл, багш сонгон шалгаруулж ажиллуулах, багшийг хөгжүүлэх, ажлыг нь үнэлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- 2.2.6. Суралцагчдад үзүүлэх үйлчилгээг нэгтгэн зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- 2.2.7. Элсэлт, төгсөлт, шилжилт хөдөлгөөний асуудлыг зохион байгуулах;
- 2.2.8. Суралцагчдын бүх төрлийн тэтгэлэг, хөдөлмөр эрхлэлттэй холбоотой ажлыг зохион байгуулах;
- 2.2.9. Төгсөгчдийн мөшгих судалгаа хийх.

2.3. Харьяаллын сургуулиудын удирдлага, сургалт, эрдэм шинжилгээний албаны чиг үүрэг:

- 2.3.1. Мэргэжил олгох болон мэргэшүүлэх сургалтын бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх;
- 2.3.2. Сургалтын стандарт, төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг тогтмол зохион байгуулж, дүн шинжилгээ хийх;
- 2.3.3. Суралцагчдын бүртгэл, тооцоо, үнэлгээ, дүн мэдээ, баримтыг хөтлөх;
- 2.3.4. Тухайн улиралд мөрдөх хичээлийн төлөвлөлт, тохиргоо хийх;
- 2.3.5. Багш нарын цагийн ачааллыг тогтоох, тооцох, ажлын гүйцэтгэлийг үнэлэх, хяналт тавих ажлыг зохион байгуулах;
- 2.3.6. Багшийн хөгжил, мэргэжлийн ур чадвар, сургах арга зүйд мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх;
- 2.3.7. Суралцагчдад сурах арга барил эзэмшихэд чиглэсэн ажил үйлчилгээг мэргэжлийн тэнхим, төвтэй хамтран зохион байгуулах;
- 2.3.8. Сургалт, эрдэм шинжилгээний алба нь эрдэм шинжилгээний хурал зохион байгуулахад хичээлийн танхим, лаборатори, дадлагын байруудыг шаардагдах сургалтын техник хэрэгслээр хангах ажлыг бусад хэлтэс, бүтцийн нэгжүүдтэй хамтарч зохион байгуулах дэмжлэг үзүүлэх.

Гурав. Сургалтын үйл ажиллагаа, хариуцах нэгж

- 3.1. Мэргэжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийг харьяаллын сургууль, мэргэжлийн тэнхим, төвүүд хариуцана.
- 3.2. Сургалтын үйл ажиллагааг ҮБХИС-ийн захирлын баталсан тухайн сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, “Сургалтын нэгдсэн хуанли”-г үндэслэн хичээлийн жил болон улирлаар төлөвлөн зохион байгуулна.
- 3.3. Хичээлийн жил нь цэргийн анхан шатны бэлтгэл сургалт, **I, II** улирлаас бүрдэнэ. Сургалт нь өдөр, эчнээ хэлбэртэйгээр зохион байгуулагдана.
- 3.4. Сургалтын улирлын үргэлжлэх хугацаа **16-18 долоо** хоногтой байна. Улирлын болон мэргэжлийн ур чадвар эзэмшсэн түвшинг тогтоох нэгдсэн шалгалтыг тус бүр **7 хоногт** багтаан төлөвлөнө.
- 3.5. Хичээлийн жилийн **I** улиралд хүндэтгэн үзэх шалтгаантай болон **F**-үнэлгээтэй шалгагдсан суралцагчдын нөхөх, хичээл дахин судлах сургалт, шалгалтыг дараагийн улирлын эхний сард нэмэлт хөтөлбөрөөр зохион байгуулна. Дахин судлах хичээлийн 1 багц цагийн үнэлгээг тухайн жилийн ҮБХИС-ийн оюутан /сонсогч, сурагч/-ы **1 багц** цагийн үнэлгээний **60 хувиар** тооцно. Дахин судлах хичээл заасан, шалгалт авсан багшийн багц цаг нь хичээлийн жилийн ноогдлын гүйцэтгэлд орж тооцогдохгүй ба багшид тухайн хичээлээр шалгалт өгсөн болон сургалтад хамрагдсан оюутнууд /сонсогч, сурагч/-ын багц цагийн нийт төлбөрийн **30 хүртэлх** хувиар бодож ажлын хөлс олгоно. **II** улиралд хангалтгүй үнэлгээ үзүүлсэн суралцагчдыг төгсөлтийн шалгалтын эрх олгох хуралдааны шийдвэрийг үндэслэн шийдвэрлэнэ.
- 3.6. Хичээлийн нэг цаг нь **45** минут байх ба хоёр цагийн хичээлийг завсарлагаагүйгээр **90** минутад багтаан явуулж болно.
- 3.7. Хээрийн хичээлийг хоногт **8-10** цагаар төлөвлөж болох ба энэ нь багшийн цагийн ачаалалд бодит цагаар тооцогдоно.
- 3.8. Сонсогч, сурагчийн өвлийн амралт ажлын **10** (сурагч-15), зуны амралт ажлын **20** хоног байна.

3.9. Лекцийн хичээлийг дамжаа, салаагаар нь бүлэглэн **50**-иас ихгүй, семинарын хичээл, лабораторийн болон дадлагын хичээлийн бүлгийг **30** хүртэлх суралцагчаар тооцож, эчнээ сургалтад бүлгийн суралцагчийн тоог харгалзахгүйгээр хичээлийн танхим, лаборатори, дадлагын байрны онцлогт нийцүүлэн зохион байгуулна. Цэргийн хөгжмийн сургуулийн онцлогт нийцүүлэн ерөнхий эрдмийн хичээлийн бүлгийг **25-30** суралцагч, мэргэжлийн болон мэргэшүүлэх хичээлийн бүлгийг **8-12** суралцагчтай ба ганцаарчилсан хэлбэрээр тус тус зохион байгуулна.

Дөрөв. Мэргэжлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөр, агуулга, багтаамж

4.1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн загвар батлах тухай” тушаалын дагуу ҮБХИС-ийн Сургалтын хэлтэс, мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн алба, мэргэжлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрүүдийг харьяаллын сургуулийн Сургалт, эрдэм шинжилгээний алба, мэргэжлийн тэнхим, төвүүдтэй хамтран боловсруулж, Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн их сургуулийн захирлаар батлуулж мөрдөнө.

4.2. Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөр боловсруулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үнэлгээ дүгнэлт өгч сайжруулах зорилго бүхий мэдлэг, дадлага, туршлагатай багш, эрдэмтэн, судлаачдаас бүрдсэн “Мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн алба”-г томилон ажиллуулах ба үйл ажиллагааг тусгай журмаар зохицуулна.

4.3. Сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хэсгүүдэд тусгагдсан хичээлүүдийн заавал судлах, сонгон судлах хичээлийн агуулга, залгамж холбоо, мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх дараалалыг оновчтой тодорхойлон харуулах зорилгоор хичээл тус бүрт үсэг ба тоогоор илэрхийлэгдсэн индексийг дараах байдлаар оногдуулна. Хичээлийн нэр, индекс давтагдахгүй. Үүнд:

- 001-099 - Багц цаг олгогдохгүй хичээл /Чөлөөт сонголтын болон секц, дугуйлангын сургалт/
- 100-199 – Мэргэжлийн боловсролын нэг дэх жилийн хичээл, цэргийн мэргэжил олгох сургалт / ерөнхий суурь хичээл, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх/
- 200-299 – Мэргэжлийн боловсролын хоёр дахь жилийн хичээл, бүлэг түүнтэй адилтгах мэргэшүүлэх сургалт / мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээл/
- 300-399 - Мэргэжлийн боловсролын гурав дахь жилийн хичээл, тасаг түүнтэй адилтгах мэргэшүүлэх сургалт / мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээл/
- 400-499 - Мэргэжлийн боловсролын дөрөв дэх жилийн хичээл, салаа түүнтэй адилтгах мэргэшүүлэх сургалт / мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээл/
- 500-599 - Рот түүнтэй адилтгах мэргэшүүлэх сургалт хамаарна /мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээл/
- 600-699- Батальон, хорооны ахлагч, түүнтэй адилтгах мэргэшүүлэх сургалт хамаарна /мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээл/

4.4 . Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрийн агуулга

4.4.1. Суралцагчдын зайлшгүй эзэмшвэл зохих мэргэжлийн боловсролын агуулга, түүний үнэлгээ, багшид болон сургалтын орчинд тавигдах үндсэн шаардлагыг боловсрол олгох сургалтын хөтөлбөр, стандартаар тодорхойлон баталгаажуулж мөрдөнө.

4.4.2. Мэргэжлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийг мэргэжлийн мэдлэг, ур чадварт тавигдах стандартыг хангахад чиглэгдсэн сургалтын төлөвлөгөө, суралцагчдад санал болгох төлөвлөгөөг чанд баримтлан хэрэгжүүлнэ.

4.4.3. “Чадамжид суурилсан сургалт”-ын мэдлэг, ур чадвар, хандлагын онцлог шаардлага, шалгуурыг хөтөлбөрт нарийвчлан тусгаж, уг шаардлагыг хангахад чиглүүлэн хичээлийн нэгж хөтөлбөрийн агуулга, арга зүйг боловсруулна.

4.4.4. Ур чадвар, чадамжуудын шалгуур үзүүлэлтүүдийг сургалтын төлөвлөгөөний агуулгын матриц, хичээл хоорондын уялдаа, холбоо, дараалал, хүрэх үр дүнгээр тогтооно.

4.5. Мэргэжлийн, боловсрол олгох сургалтын хөтөлбөрийн багтаамж

4.5.1. Мэргэжлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөр нь сургалтын агуулга, төвшингөөс шалтгаалан дараах байдалтай байна. Үүнд:

а/ Цэргийн хөгжмийн коллежийн мэргэжлийн боловсрол олгох сургалтын **2,5** жилийн сургалт **90** багц цагаас доошгүй, техникийн боловсрол олгох сургалтын **1,5** жилийн сургалт **45** багц цагаас доошгүй байна.

б/ Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн цэргийн мэргэжил олгох сургалт нь **36** багц цаг, төгсөлтийн дараах сургалт нь **4-30** багц цагийн багтаамжтай байна.

ҮБХИС-ийн захирлын 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/133 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон/

4.5.2. Мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгын багтаамж, нормативт хугацааг дараах байдлаар тогтооно.

Олгох зэрэг	Элсэгчийн боловсролын түвшин	Өдөр		Эчнээ	
		Судлах багц цаг	Суралцах хугацаа	Судлах багц цаг	Суралцах хугацаа
Мэргэжлийн боловсрол	Цэргийн хөгжмийн коллеж				
	Суурь боловсрол	90-95 багц цаг	2.5 жил	-	-
	Бүрэн дунд	45-50 багц цаг	1.5 жил	-	-
	Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв				
	Бүрэн дунд /Цэргийн мэргэжил олгох сургалт/	36 багц цаг	1жил	-	-
	Бүрэн дунд түүнээс дээш /Мэргэшүүлэх сургалт/	4-30 багц цаг	1-9 сар	4-30 багц цаг	1-9 сар
	- Бүлгийн захирагчийн дамжаа	4 багц цаг			
	- Тасгийн захирагчийн дамжаа	12 багц цаг			
- Салааны ахлагчийн дамжаа	12 багц цаг				
- Ротын ахлагчийн дамжаа	6 багц цаг				
- Батальон, хорооны ахлагчийн дамжаа	30 багц цаг				

ҮБХИС-ийн захирлын 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/133 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон/

4.6. Мэргэжлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөр

4.6.1. Мэргэжлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийг ҮБХИС-ийн захирал батална.

4.6.2. Мэргэжлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа нь:

а/ Цэргийн хөгжмийн коллежийн хувьд мэргэжлийн боловсролын **2,5** жилийн сургалт **5**, техникийн боловсролын **1,5** жилийн сургалт **3** хүртэл улирал;

б/ Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн цэргийн мэргэжил олгох сургалт **1** жил, мэргэшүүлэх /төгсөлтийн дараах/ сургалт **1-9** сар үргэлжлэхээр байна.

ҮБХИС-ийн захирлын 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/133 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон/

4.6.3. Мэргэшүүлэх эчнээ сургалт нь хичээлийн жилд хоёр удаагийн цугларалтаар зохион байгуулагдана.

4.6.4. Цэргийн мэргэжлийн хувьд хөтөлбөрийн /мэргэжлийн/ чиглэл сонгох ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар явуулна.

4.6.5. Суралцагчийн хөтөлбөр, мэргэжил сонголтыг ҮБХИС-ийн захирлын тушаалаар эцэслэн батална.

4.6.6. Мэргэжлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрт суралцагч сургалтын төлөвлөгөөний дагуу танилцах дадлагыг ажлын **10**, удирдах ур чадварын дадлагыг ажлын **15**, мэргэжил /үйлдвэрлэл/-ийн дадлагыг ажлын **20** хоногоос доошгүй хугацаагаар гүйцэтгэнэ. Дадлагын удирдамж, төлөвлөгөөг мэргэжлийн тэнхим /төв/ боловсруулж, харьяаллын сургуулийн захирал албажуулна.

4.6.7. Сургалтын хөтөлбөрт тусгагдсан заавал судлах хичээлийн багц цагийг бүрэн хангасан, үнэлгээний голч дүн **2,0**-оос доошгүй үнэлгээтэй, нийт судалсан хичээлүүдэд **F** үнэлгээгүй байх шаардлагыг хангасан тохиолдолд төгсөлтийн шалгалтад орох эрх олгоно.

4.6.8. Суралцсан нийт хугацааны голч дүн нь **3,9**-ээс дээш үнэлгээтэй төгсөгчдөд онцгойлох диплом олгоно.

4.6.9. Онцгойлох дипломтой төгсөгчдөд ҮБХИС-ийн бакалаврын сургалтын хөтөлбөрт суралцах урилга олгож болно. /ЭЕШ-ын шаардлагыг хангасан байна./

Тав. Сургалтын төлөвлөгөө, кредит цаг

5.1. Мэргэжлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрт тусгагдсан сургалтын төлөвлөгөөний бүтэц агуулга, шаардлагыг мэргэжлийн тэнхим, профессорын баг, багш, суралцагч, төгсөгч, ажил олгогчдын санал, зөвлөмжийг харгалзан тухайн хөтөлбөрийн зорилго, зорилт, хүрэх үр дүнд нийцүүлэн мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн алба боловсруулна.

5.2. Сургалтын төлөвлөгөөг Сургалтын хэлтэс болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн албаны дүгнэлтийг үндэслэн Хөдөлмөрийн нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан хөтөлбөрийн нэр, индекс, тавигдах шаардлагыг удирдлага болгон, ҮБХИС-ийн захирал баталж, сургуулийн хэмжээнд дагаж мөрдөнө.

5.3. Сургалтын төлөвлөгөөний ерөнхий суурь хэсэг нь Цэргийн анхан шатны бэлтгэл сургалтаар судлах **4** багц цаг, ерөнхий бэлтгэл сургалтаар судлах **8** багц цагийн хичээлээс бүрдэнэ.

5.4. Цэргийн хөгжмийн коллежийн мэргэжлийн боловсрол, техникийн боловсрол, сургалт нь доорх байдлаар төлөвлөгдөнө.

Мэргэжлийн боловсрол, сургалтын төлөвлөлт:

- А.Ерөнхий суурь хэсгийн эзлэх хувь **30** хувь **+/- 5** хувь/ байхаар төлөвлөх;
- Б.Мэргэжлийн суурь хэсгийн эзлэх хувь **20** хувь **+/- 5** хувь/ байхаар төлөвлөх;
- В.Мэргэшүүлэх хэсгийн эзлэх хувь **50** хувь байх **+/- 5** хувь/ байхаар төлөвлөх;

Б.В хэсгийн буюу онол дадлагын харьцаа нь **30:70 хувь +/- 5 хувь/**

Техникийн боловсрол, сургалтын төлөвлөлт:

- А.Ерөнхий суурь хэсгийн эзлэх хувь **25** хувь **+/ -5** хувь /байхаар төлөвлөх;
- Б.Мэргэжлийн суурь хэсгийн эзлэх хувь **35** хувь **+/ -5** хувь /байхаар төлөвлөх;
- В.Мэргэшүүлэх хэсгийн эзлэх хувь **45** хувь байх **+/ -5** хувь /байхаар төлөвлөх;

Б.В хэсгийн буюу онол дадлагын харьцаа нь **40:60 хувь+/ -5** хувь /байхаар тус тус төлөвлөнө.

/ҮБХИС-ийн захирлын 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/133 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон/

5.5. Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл тус бүр нэгж хөтөлбөр, сурах бичигтэй байх ба тэдгээрт тухайн хичээлийн стандартагуулга тодорхойлогдсон байна.

5.6. Хичээлийн нэгж хөтөлбөр болон стандартад тухайн хичээлийн зорилго, зорилтууд, эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар /чадамж/, хандлага хүрэх үр дүн, агуулгын хүрээ, цагийн багтаамж, ашиглах ном, сурах бичиг, бусад хэрэглэгдэхүүн, бие даах ажлын агуулга, хэлбэр, тоо хэмжээ, хичээлийн явцын ерөнхий төлөвлөлт, суралцагчийн явцын болон улирлын үнэлгээний шалгуурыг тодорхой тусгана.

5.7. Хичээлийн нэгж хөтөлбөрийг мэргэжлийн тэнхим, төвийн профессорын баг, тухайн хичээлийг заах **2**-оос доошгүй багш боловсруулж, мэргэжлийн боловсролын

хөтөлбөрийн албаар хянуулж, тэнхим, төв, сургалт арга зүйн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, тэнхимийн дарга баталгаажуулан мөрдөнө.

5.8. Багш хичээлийн нэгж хөтөлбөрийн агуулгыг суралцагчдад бүрэн эзэмшүүлэх, суралцагч бүрэн эзэмших үүрэгтэй.

5.9. Хичээлийн агуулгыг багц /кредит/ цагаар хэмжинэ.

5.9.1. Багц цагийн задаргааг дараах байдлаар тодорхойлно.

Багц цагийн задаргаа

Бүгд багц цаг	Лекц	Семинар, бүлгийн сургууль	Лаборатори дадлага	БУДБД	Хонхны цаг	Оюутны бие даалт
1 багц цаг	2	-	42	-	44	4
	4	8	24	4	40	8
	4	-	36	-	40	8
	6	8	18	8	40	8
	-	-	48	-	48	-
	-	32	-	8	40	8
	-	16	24	-	40	8
	8	-	24	8	40	8
2 багц цаг	8	16	48	8	80	16
	8	-	72	-	80	16
	8	8	60	4	80	16
	12	16	36	16	80	16
	16	-	48	16	80	16
	-	-	96	-	96	-
	-	32	48	8	80	8
3 багц цаг	16	32	48	24	120	24
	16	16	64	24	120	24
	-	-	144	-	-	-
	16	28	54	22	120	24
		32	96	-	128	16
4 багц цаг	32	-	96	32	160	32
	-	-	192	-	192	-
		16	144	-	160	32
5 багц цаг	-	48	168	-	216	24
	-	-	240	-	240	-

- Нэг 7 хоногийн сургалт нь 1 багц цагийн сургалтын агуулгыг илэрхийлнэ.

- Хичээлийн кредит цаг нь тухайн хичээлийн агуулгыг илэрхийлэх бүхэл тоо байх бөгөөд хэмжээ нь долоо хоногт тухайн хичээлийг судлах цаг, хэлбэрээс хамаарна.

- 1 цагийн лекцийн хичээл нь 2 цагийн бие даах ажил, 2 цагийн семинарын хичээл нь 1 цагийн бие даах ажил, дадлагын хичээлийг бие даах ажил байхгүйгээр төлөвлөж, хичээл сургалтыг төлөвлөлтийн дагуу зохион байгуулна. Тухайлбал:

1 улирлын турш 7 хоногт 1 цагийн лекцийн хичээл+2 цагийн бие даах ажил+ бусад бүх төрлийн сургалтын ажил)ангийн ажил, реферат, график тооцооны ажил, гэрийн даалгавар, шалгалт, шүүлэг(-г багтаасан багц;

2 цагийн семинарын хичээл +1 цагийн бие даах ажил+ бусад бүх төрлийн сургалтын ажил)ангийн ажил, реферат, график тооцооны ажил, гэрийн даалгавар, шалгалт, шүүлэг(-г багтаасан багц.

5.9.2. Өдрийн хэлбэрээр суралцагчид суралцах хугацаандаа хичээлийн нэг улиралд 16-аас ихгүй багц цагийн хичээл судлахаар төлөвлөнө. Сонсогч, сурагч нарт цэргийн мэргэжлийн хичээлийг нэмэлтээр 4 хүртэл багц цагаар төлөвлөж болно.

5.9.3. Эчнээ сургалтын нэг багц цагт ноогдох танхимын хичээл **16** цаг, бие даалт **32** цаг байна. Танхимд судалсан хичээл, бие дааж гүйцэтгэх ажлын даалгаварт өгөх үнэлгээг хичээлийн хөтөлбөрт тодорхой тусгана.

Зургаа. Суралцагчдын элсэлт

6.1. Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт элсэгч нь:

а/ Цэргийн хөгжмийн коллеж /ЦХК/ нь хөгжимдөх урлаг хөтөлбөрт Ерөнхий боловсролын сургуулийн **9 дүгээр** анги төгссөн хөгжмийн авьяастай сурагчдыг элсүүлэн 4 жил цэргийн үлээвэр хөгжмийн сурагчаар суралцуулж, дипломын боловсрол бүхий хөгжимчин ахлагчаар төгсгөнө.

б/ Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв /БХМСҮТ/ нь цэргийн зэвсэглэл, техник, тусгай тоноглол, төхөөрөмжийн чиглэлээр мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт бүрэн дунд ба түүнээс дээш боловсролтой, ЭЕШ өгсөн **22 хүртэлх** насны иргэдийг суралцуулан цэргийн мэргэжил эзэмшүүлж, Зэвсэгт хүчний ахлагчийн албанд шилжүүлнэ.

Мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрт элсэгчдээс ЗХЖШ-ын даргын 2017 оны 505 дугаар тушаалаар батлагдсан “Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт”-ын цэргийн алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийн нормативын дагуу насны ангиллаар шалгалт авна. Бие бялдар, эрүүл мэндийн шаардлага, шалгуур үзүүлэлт хангасан цэргийн алба хаагчдыг онол, ур чадварын түвшин тогтоох шалгалтад хамруулна.

/ҮБХИС-ийн захирлын 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/133 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон/

6.2. Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт элсэгчид **165 см**-ээс дээш өндөртэй, **60 кг**-аас **багагүй жинтэй, биеийн ил хэсэгт сорвигүй, биед шивээсгүй** байна. /2017 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын 144 дүгээр тогтоол/

Цэргийн хөгжмийн коллежид элсэх сурагчид нь бие бялдрын ерөнхий хөгжил хэвийн байх шаардлагыг хангана.

/ҮБХИС-ийн захирлын 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/133 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон/

6.3. Цэргийн албанд эрүүл мэндээрээ тэнцэх нь Цэргийн төв эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгээр тогтоогдож баталгаажсан байх.

6.4. Бие бялдрын түвшин тогтоох шалгалтын ерөнхий болон тусгай шаардлагыг элсэлтийн журмаар зохицуулна.

Долоо. Суралцагчдын шилжилт, хөдөлгөөн

7.1. Цэргийн хөгжмийн коллежийн мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрт өдрөөр суралцагч нь сургалтын хөтөлбөрийг бүрэн хангаж, үнэлгээний голч дүн 2,7-оос доошгүй үнэлгээтэй бол техникийн боловсрол, сургалтын хөтөлбөрт шилжин суралцаж болно.

/ҮБХИС-ийн захирлын 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/133 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон/

7.2. Бусад сургуулийн ижил төстэй мэргэжлийн боловсролын хөтөлбөрт суралцагчид нь Цэргийн хөгжмийн коллежид шилжин ирж суралцахыг зөвшөөрнө. Шилжин суралцагч нь бүрэн дунд боловсролтой, техникийн боловсрол, сургалтын хөтөлбөрт элсэх шалгуурыг хангасан, 2,8-аас доошгүй голч дүнтэй, үлээвэр, цохивор, утсан хөгжмийн зэмсгийг тодорхой түвшинд эзэмшсэн байвал зохино.

/ҮБХИС-ийн захирлын 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/133 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон/

7.3. Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд журмын 8.1, 8.2 дахь заалтууд хамаарахгүй.

/ҮБХИС-ийн захирлын 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/133 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон/

Найм. Суралцагчдад чөлөө олгох, түдгэлзүүлэх, сургуулиас хасах

8.1. Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчдад **1 жилийн хугацаагаар чөлөө олгохгүй.**

8.2. Цэргийн хөгжмийн коллежийн суралцагч нь ар гэрийн гачигдал, эрүүл мэндийн байдал, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар суралцагчдад **1 жилийн хугацаагаар чөлөө олгож болох бөгөөд чөлөөг суралцах хугацаанд нь зөвхөн 1 удаа** олгоно.

8.3. Суралцагчдад хичээлээс чөлөө олгох хугацааг **36** цагаас хэтрэхгүй байхаар тооцно. Тэнхимийн дарга **2** хоногийн, харьяаллын сургуулийн захирал **4** хоногийн, сургалтын хэлтсийн дарга **5** хоногийн, ҮБХИС-ийн захирал, дэд захирал сургуулийн дүрэм, цэргийн дүрмээр тогтоосон хэм хэмжээг баримтлан суралцагчдад чөлөө олгож болно.

8.4. Цэргийн хөгжмийн коллежийн суралцагчийг **дараах тохиолдолд түдгэлзүүлэх**

а/ Мэргэжлийн дадлага хийгээгүй, тайлан хамгаалаагүй;

б/ Эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар нэг улиралд **9-өөс дээш багц цагийн** хичээлд хамрагдаагүй;

в/ Суралцах хугацаандаа жирэмсэн болсон.

8.5. Дараах тохиолдлуудад суралцагчийг сургуулиас хасах үндэслэл болно.

а/ Нэг улиралд 1 ба түүнээс дээш хичээлд “**F**” үнэлгээтэй, хичээлийн жилийн эцсээр голч дүн нь 2,0-д хүрээгүй, хөгжимдөх ур чадварын шалгалтад 2 улирал дараалан “**F**” үнэлгээ үзүүлсэн тохиолдолд;

б/ Хүндэтгэх шалтгаангүйгээр нэг улиралд **36-аас** дээш цагийн хичээл тасалсан;

в/ Батлан хамгаалах мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн сонсогч нь мэргэжлийн дадлага хийгээгүй, тайлан хамгаалаагүй;

г/ Нэг жилийн чөлөөний хугацаа дууссан боловч сургуульдаа эргэн суралцах хүсэлт өгөөгүй;

д/ Төрийн хууль тогтоомж, нийгмийн хэв журам зөрчиж, гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон;

е/ Монгол Улсын цэргийн нийтлэг дүрмүүд болон ҮБХИС-ийн дүрэм, журам зөрчсөн, сургуулийн нэр хүнд, сонсогч, сурагчийн ёс зүйд харшилсан /мансууруулах бодис, согтууруулах ундаа хэрэглэсэн, танхайрсан г.м/ сахилгын зөрчил гаргасан;

ё/ ҮБХИС-ийн захирлын 2020 оны А/64 тоот тушаалаар батлагдсан “Сонсогчдын бие бялдрын норматив”-ын дагуу улирал бүр шалгалт авч 2 удаа “**F**” үнэлгээтэй шалгагдсан;

з/ Эрүүл мэндийн болон бусад шалтгаанаар **16-аас дээш багц цагийн** хичээлд хамрагдах боломжгүй болсон;

ж/ Халдварт өвчин туссан түүнийгээ нуун дарагдуулах, бусдад санаатайгаар халдаасан.

и/ Түдгэлзсэн суралцагч нь 1 жилийн хугацаанд үргэлжлүүлэн суралцах хүсэлтээ гаргаагүй.

ҮБХИС-ийн захирлын 2020 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн А/133 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт орсон/

8.6 Журмын **9.3 а, б, в, г** заалтаар түдгэлзсэн суралцагч нь 1 жилийн хугацаанд зөрчлөө арилган Сургалтын хэлтэст үргэлжлүүлэн суралцах хүсэлтээ гарган, шийдвэрлүүлж болно.

8.7. Суралцагчдад хичээлээс чөлөө олгох хугацааг холбогдох дүрэм, цэргийн нийтлэг дүрмүүдээр тогтоосон хэм хэмжээг баримтлан тогтооно.

Ес. Сургуулиас олгох албан болон албан бус бичиг баримт

9.1. Суралцагч бүр хувийн хэрэгтэй байна. Хувийн хэрэгт тухайн суралцагчийн сургуульд элсэх үед бүрдүүлсэн материалыг эх хувиар нь авч харьяаллын сургуулийн Сургалт, эрдэм шинжилгээний албанд хадгална.

9.2. Суралцагч бүр тус сургуульд суралцдаг болохыг гэрчилсэн суралцагчийн үнэмлэх, бичиг баримттай байж, байнга биедээ авч явах ба хаяж гээгдүүлсэн тохиолдолд нөхөн олгоно.

9.3. Суралцагч бүрийн шалгалт өгсөнийг нотлох суралцагчийн хөгжлийн дэвтэртэй байна. Сурлагын дүнгийн дэвтрээ өөртөө хадгалах ба суралцагчийн хувийн хэргийн

баяжилт, тодорхойлолтыг салаа, салбарын захирагч, анги даасан багш хамтарч хариуцан хөтөлнө.

9.4. Тус сургуульд суралцсан хугацаанд судалсан хичээлийн багц цаг, улирлын шалгалтын болон голч дүнгийн тодорхойлолтыг харьяаллын сургуулийн Сургалт, эрдэм шинжилгээний алба хариуцан гаргаж баталгаажуулж өгнө.

9.5. Мэргэжлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрөөр төгсөгчдөд боловсролын зэрэг эзэмшсэнийг гэрчлэх диплом, үнэмлэх, гэрчилгээ, энгэрийн тэмдэгийг хүндэтгэлтэйгээр гардуулна.

9.6. Төгсөгчдийн эх материалыг холбогдох хүний нөөцийн байгууллагуудад Захиргаа удирдлагын хэлтэс шилжүүлэн, хүлээлгэж өгнө.

9.7. Сургуулиас хасагдсан, өөр сургуульд шилжсэн суралцагчийн хувийн хэрэг, бичиг баримтыг холбогдох төлбөр тооцоог барагдуулсны дараагаар баримтжуулан хүлээлгэж өгөх үүргийг харьяаллын сургуулиудын Сургалт, эрдэм шинжилгээний алба хариуцна.

9.8. Сургууль төгсөгч хаяж үрэгдүүлсэн, ашиглах боломжгүй болсон, овог нэр, регистрийн дугаар солих шаардлагатай болсон боловсролын бичиг баримтыг /диплом, гэрчилгээ, үнэмлэх/ тухайн төгсөгчийн хүсэлт, бүрдүүлсэн материалыг үндэслэн, зохих төлбөртэйгээр сургуулийн захирлын тушаалаар дахин олгоно.

9.9. Мэргэжлийн диплом, үнэмлэх, гэрчилгээг нөхөн авахад дараах бичиг, баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

- Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлуулж хүчингүй болгосныг нотлох зар;
- Сургууль төгссөн тухай захирлын тушаалын хуулбар /архивын лавлагаа/;
- Диплом, үнэмлэх, гэрчилгээний хуулбар / архивын лавлагаа/;
- Өргөдөл;
- Төгсөгч диплом, үнэмлэх, гэрчилгээ үрэгдүүлсэн тохиолдлоо баталгаажуулж, авахыг хүсвэл дахин олголтын үйлчилгээний хөлсийг тухайн хувь хүн өөрөө хариуцна;
- Дахин олголтын суурь хураамж нь тухайн хичээлийн жилийн 1 багц цагийн үнэлгээтэй тэнцүү байна.

9.10. Дээрх материалыг бүрдүүлэн ҮБХИС-ийн Сургалтын хэлтэст хүлээлгэн өгөх ба материал хүлээн авснаас хойш ажлын 14 хоногт багтаан диплом, үнэмлэх, гэрчилгээг нөхөн олгоно.

“МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТЫН ЖУРАМ ОРСОН ЗАРИМ НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

Журамд орсон нэр, томьёонуудыг Монгол Улсын хууль, боловсролын салбарт мөрдөгдөж буй дүрэм журам, бусад албан ёсны баримт бичгүүдэд доорх байдлаар томьёолон тайлбарласнаар оруулав.

1. Боловсролын агуулга: Боловсролын тухайн түвшинд эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, чадамж, төлөвшлийн цогцыг хэлнэ.

2. Мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх сургалтын агуулга нь: Суралцагчид ажил, мэргэжлийн үндэсний ангиллаар тодорхойлсон мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, төлөвшүүлэхэд чиглэнэ. Мэргэжлийн боловсролын агуулга нь анхан шатны бэлтгэл, ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хэсгээс бүрдэнэ.

3. Мэргэжлийн боловсрол: Тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг хэлнэ.

4. Техникийн боловсрол: Техник, технологийн үйл ажиллагааг гүйцэтгэх, удирдах хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн үйлдвэрлэл, техник, технологийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг хэлнэ.

5. Чадамж: Хөдөлмөрийн орчинд ажил олгогчийн зүгээс тавих мэргэжлийн шаардлагыг биелүүлэх түвшинд суралцагчийн эзэмшсэн байвал зохих мэдлэг, чадвар, дадал, хөдөлмөрийн соёлын төлөвшлийг хэлнэ.

6. Чадамжид суурилсан сургалт: Мэргэжлийн боловсрол сургалтаар ажлын байранд тухайн ажлыг ажил, мэргэжлийн стандартын дагуу гүйцэтгэхийн тулд эзэмших шаардлагатай мэдлэг, ур чадвар, хандлагыг олгох, төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

7. Чадамжийн нэгж: Тухайн нэгж чадамжийн түлхүүр хэсгүүд буюу түүнийг бүрдүүлж буй үзүүлэлтүүд юм.

8. Сургалтын орчин: Боловсролын стандартыг хэрэгжүүлэхэд шаардагдах материаллаг нөхцөл болон сурах, сургах харилцаа;

9. Хөтөлбөр /Curriculum/: Хоорондоо уялдаа холбоо бүхий бүрэлдэхүүн хэсгүүдээс бүрдсэн тодорхой шатны боловсролын зэрэг /degree/ олгоход нийцүүлсэн суралцагчийн сурах хөтөлбөр юм. Хөтөлбөрт сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, сургалтын арга зүй, суралцах орчин, багш, суралцагчдад тавигдах шаардлага, үнэлгээ, чанарын баталгаажуулалт, удирдлагын мэдээллийн систем, харилцаа, хамтын ажиллагаа, төгсөгчдийн эзэмших ур чадвар зэргийг тусгана.

10. Сургалтын төлөвлөгөө: Хөтөлбөрийн 1 хэсэг ба судлах хичээлийн жагсаалт, агуулга багтаамж, дараалал, дадлагын төрлийг тусгасан баримт бичиг;

11. Хичээлийн хөтөлбөр: Сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл тус бүрийн индекс, суралцагчийн эзэмшвэл зохих онол, дадлага, ур чадварын агуулга, сэдэвчилсэн төлөвлөгөө, үнэлгээ, арга зүй, хичээлийн багтаамж, ашиглах ном, сурах бичиг, эх сурвалжийн жагсаалтыг тодорхойлсон баримт бичиг;

12. Багц цаг /кредит/: Дээд боловсролын байгууллагын боловсролын зэрэг олгох сургалтад тавигдах стандарт шаардлага, үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт, зохион байгуулалтын харилцааг зохицуулах, сургалтын агуулгын багтаамжийг жиших нэгж бөгөөд багш, суралцагчдын сургалтын ажлын хэмжээ, ачаалал, тавигдах шаардлага, сургалтын төлбөрийг тооцох үндсэн хэмжүүр;

13. Хичээлийн багц цаг: Хичээлийн агуулгыг харуулах бүхэл тообайна. Нэг багц цагийн агуулга, багтаамжнь хичээлийн 48 цагтай тэнцүү байна. Хичээлийн багц цаг нь лекц, семинар, дадлага /лаборатори/, тэдгээрт харгалзах бие даан гүйцэтгэх ажлын цагуудаас бүрдэнэ.

14. Танхимийн цаг: Хичээлийг танхимд судлахад зарцуулж байгаа цагийг хэлнэ. Суралцагчийн сурах үйл ажиллагаанд 1 долоо хоногт зарцуулах дараах багц бүрийг нэг багц цаг гэж тодорхойлно.

15. Хичээлийн цаг: 45 минут байх ба 2 цагийн хичээлийг 90 минутад багтаан явуулж болно.

16. Хичээлийн индекс: Сургалтын төлөвлөгөөний цэсэд тусгагдсан хичээлүүдийн залгамж холбоо, агуулгын гүнзгийрэлт, сонголтын мэдээллийг харуулах зорилгоор хичээлүүдэд үсэг (тухайн хичээлийн шинжлэх ухааны салбарын англи нэрийн товчлолын эхний 3-4 үсгээр) ба тоо (тухайн хичээлийн агуулгын эрэмбэ дараалал, хичээл хоорондын уялдаа холбоог харгалзан 3 оронтой)-гоор илэрхийлэгдсэн индекс оногдуулна. Хичээлийн индексийн тоон хэсгийн эхний орон нь тухайн хичээлийн түвшнийг, дараагийн хоёр орон нь уг хичээлийн дугаарыг заана.

17. Чөлөөт сонголтын хичээл: Суралцагч өөрийн хүсэл сонирхлоороо чөлөөтэй сонгон судлахад зориулагдан хичээл, секц, дугуйлангын хичээлүүд;

18. Ерөнхий суурь хичээл /General Education/: Шинжлэх ухааны үндэс, олон урьгалч үзэл баримтлалын учир шалтгааныг таньж мэдэхийн зэрэгцээ төрөлх болон гадаад хэлээр зөв ярих, бичих, харилцах, үр дүнтэй хамтарч ажиллах, харилцан суралцах, тоон болон тоон бус мэдээллийг боловсруулах чадвар эзэмших зорилго агуулсан дээд боловсролын түвшний заавал болон сонгон суралцах хичээлүүд;

19. Мэргэжлийн чиглэлийн суурь хичээл /Core/: Оюутанд хөтөлбөр сонгоход зайлшгүй хэрэгцээтэй мэргэжлийн чиглэлийн суурь боловсролын мэдлэгийг олгох, тухайн талбарт асуудал шийдвэрлэх, бүтээлчээр сэтгэх мэдлэг ур чадвар эзэмшүүлэх агуулга бүхий суурь хичээл;

20. Мэргэжлийн хичээл /Major course/: Тодорхой мэргэжлийн мэдлэг, ур чадвар өгөхөд чиглэсэн, суралцагчид шинжлэх ухаан, мэргэжлийн чиглэл, салбараар төвлөрч, гүнзгийрэн судлах боломж олгодог заавал болон сонгон судлах хичээл;

21. Лекцийн хичээл: Шинжлэх ухааны онолын суурь мэдлэгийг системтэй өгөх зорилготой багшийн тайлбарлан ярих болон сурган хүмүүжүүлэх бусад арга, хэрэгслийг хэрэглэж буй сургалтын хэлбэр;

22. Семинарын хичээл: Онолын материалыг гүнзгийрүүлэн судлах, ерөнхийлөн дүгнэх, сэтгэхүйн шүүмжлэлт шинжийг хөгжүүлэх, мэдлэг хуримтлуулах, бүтээлч санаачлага болон ур чадварт суралцах, эргэцүүлэл хийх, өөрийн үзэл бодлыг үндэслэлтэй хамгаалах, илэрхийлэх дадал бүрэлдүүлэхэд чиглэгдсэн сургалтын хэлбэр;

23. Лабораторийн хичээл: Анги, лабораторид багшийн тусламжтайгаар онолын мэдлэгийг бодит амьдралын үйл ажиллагаанд чиглэсэн туршилт дээр үндэслэн дадлага олгох буюу ажлын ур чадвар эзэмшүүлэх хичээл. Тус хичээл нь лабораторийн багаж, тоног төхөөрөмж хэрэглэх, лабораторийн тайлан бичих, өгөгдөлд дүн шинжилгээ хийх зэрэг бие даалтын хэлбэрийг агуулж болно.

24. Дадлага: Хамтарсан сургалт, сургууль байгууллага хоорондын гэрээний дагуу олгож буй дадлага, дагалдан судлах зэргээр мэргэжлийн ур чадварыг хөгжүүлэх зорилготой. Дадлагын байранд 32 цаг, бие даан суралцахад 16 цаг зарцуулах нь 1 багц цагтай тэнцүү байна.

25. Явцын үнэлгээ: Тухайн хичээлийн явцад суралцагч хөтөлбөрийн дагуу эзэмшвэл зохих мэдлэг, ур чадвар, чадамжыг хэрхэн эзэмшиж буйг үнэлж, цаашид багш, суралцагчийн сургах, сурах үйл ажиллагааг идэвхижүүлэх үзүүлэлт.

26. Улирлын шалгалт: Тухайн хичээлийг судалж дууссаны дараа уг хичээлийн хөтөлбөрт заасан мэдлэг, ур чадварыг хэрхэн эзэмшсэнийг үнэлэх гол үзүүлэлт.

27. Нэгдсэн шалгалт: Боловсролын зэрэг олгох хөтөлбөрийг бүрэн судалсан суралцагчийн тухайн хөтөлбөрөөр эзэмшсэн мэдлэг, ур чадвар, чадамж нь БХИС-ийн төгсөгчдөд тавигдах шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлэх үндсэн үзүүлэлт.

28. Голч оноо: Багц цаг бүхий хичээл бүрээр суралцагчийн авсан оноог багц цагаар нь үржүүлж, тэдгээрийн нийлбэрийг багц цагийн нийлбэрт хуваасан /арифметикийн жинлэсэн дундаж/ үзүүлэлт.

29. Голч дүн: Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, ур чадвар, чадамжын тоон болон чанарын үнэлгээний нэгдэл бөгөөд голч онооны адил аргачлалаар бодогдоно.

30. Хичээлээр эзэмшсэн байх дадлага, чадварын стандарт: Тодорхой хичээлээр суралцагчийн заавал биеэр хийж сурсан байхдадлага ажлууд, ажил бүрийг гүйцэтгэх дараалал, журам, норматив юм.